



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/472

Бсөнбулаг

Хөлбөмбөгийн шигшээ багийн  
тамирчдын замын зардалд дэмжлэг  
үзүүлэх тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10,11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 30 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Дархан-Уул аймагт зохион байгуулагдах насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах "Үндэсний цом"-ын тэмцээнд оролцох аймгийн хөлбөмбөгийн шигшээ багийн тамирчдын замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 1,612,800 (нэг сая зургаан зуун арван хоёр мянга найман зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

